



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 79

Мандалговь

Хөрөнгө шилжүүлэх тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар 77.2.3, 77.3 заалтуудыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 38,900,000.00 /Гучин найман сая есөн зуун мянган төгрөг/-ний өртөгтэй хийгдсэн “Аймгийн төвийн малчин хорооллын айл өрхүүдийн цахилгаан хангамжийг сайжруулах, дэд өртөө” ажлыг “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ын харъяа “Дундговь Цахилгаан түгээх сүлжээ салбар”-т шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Үндсэн хөрөнгийг зохих журмын дагуу данс бүртгэлдээ бүртгэж авахыг аймгийн Цахилгаан түгээх сүлжээ салбарын дарга Г.Мягмарсүрэнд даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ц.Мөнгөнцоожид үүрэг болгосугай.

ТЭРГҮҮЛЭГЧ



Б.ДОРЖСҮМБЭР